

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

№ 22/29

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасахыг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт, Компанийн Үндсэн хөрөнгө бараа, материалын журмын 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон нийт 4,639,739.84 (дөрвөн сая зургаан зуун гучин есөн мянга долоон зуун гучин ес зууны наян дөрөв) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн үндсэн хөрөнгийн комиссын хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах буюу нягтлан бодох бүртгэлд зохих өөрчлөлт оруулах зэрэг ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу зохион байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

№ 22/30

Улаанбаатар хот

Чанаргүй болон муу активыг зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 998 тоот тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6.4 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компаниас гаргасан саналыг үндэслэн 270,000,000 (хоёр зуун далан сая) хүртэлх төгрөгтэй тэнцэх чанаргүй болон муу активыг, тэдгээрт тооцогдсон 15,500,000 (арван таван сая таван зуун мянга) төгрөгийн төлөгдөөгүй шимтгэл болон хүүгийн авлагын төлбөрийг Зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах, түүнтэй холбоотой холбогдох нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хийх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
2. Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааг холбогдох хууль, тогтоомж болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.
3. Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааны гүйцэтгэлийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д даалгасугай.

